

АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТҮВШИНД БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар
2021 он


1	АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ТАРХВАР ЗҮЙ ОНОШИЛГОО	6
2	АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ЭМЧИЛГЭЭ, ХЯНАЛТ.....	17
3	ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ЗӨВӨЛГӨӨ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДҮГНЭЛТ ӨГӨХ	32
4	АГ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ	46
5	ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ АЛГОРИТМ	47

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод “ЭРҮҮЛ ЗҮРХ-ЭРҮҮЛ УЛААНБААТАР” хөтөлбөр амжилттай хэрэгжиж, өнөөгийн байдлаар хүн амын дунд даралт ихсэлтийн үр дүнтэй хяналтын хувь 4 дахин нэмэгдэж, систолын дундаж даралт 8 мм МУБ-аар буурсан эерэг үзүүлэлтүүд гарсан байна.

Энэхүү сайн туршлагыг Монгол улсын хэмжээнд нэвтрүүлж, хөдөө орон нутгийн эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын артерийн гипертензийн менежментийг бэхжүүлэх, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Монголын сумын эмч, мэргэжилтний холбооноос энэхүү номыг хэвлүүллээ.


ЭРҮҮЛ ЗҮРХ – ЭРҮҮЛ УЛААНБААТАР

ДЭЛХИЙН ОЛОН УЛС ОРНООС СОНГОГДСОН 3 ХОТЫН 1 БОЛЛОО



Дэлхий дахинд жил бүр 18 сая хүн зүрх судасны өвчнөөр нас бардаг ба эдгээр нас баралтын талаас илүү буюу 9,4 сая нь цусны даралт ихсэлтээс үүдэлтэй байна.

Монгол улсад зүрхний шигдээс, цус харвалт зэрэг зүрх судасны тогтолцооны өвчин нас баралтын тэргүүлэх шалтгаан болдог (Зураг 1). 100,000 хүн амд ногдох цус алдах хэлбэрийн тархины цус харвалтын нас баралтаар манай улс дэлхийд 1-рт бичигдэж, дэлхийн дунджаас бараг 4 дахин их байгаа тоо баримт бий (Зураг 2). Эдгээр тоо баримт нь нийт хүн амын дунд цусны даралт ихсэлтээс сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжин дэлгэрүүлэх, цусны даралт ихсэлттэй иргэдийн эмчилгээ хяналтыг сайжруулах нэн тулгамдсан шаардлага байгааг харуулж байна.



Зураг 1.

Зураг 2.

“ЭРҮҮЛ ЗҮРХ -ЭРҮҮЛ УЛААНБААТАР” ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ЧИГЛЭЛ

ҮНДСЭН 5 БАГЦ АЖИЛ

Анхан шатанд артерийн гипертензийн (АГ) тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах

- Нийслэлийн 142 өрхийн эрүүл мэндийн төвийн 1400 эмч, сувилагчдыг сургах
- Нийслэлийн 1000 гаруй эм зүйчдийг сургах

“Үйлчүүлэгч төвтэй” тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох

- Цахим бүргэлийн системийг нэвтрүүлэх (эмчийн үзлэгийг боловсронгуй, үйл ажиллагааг эргэн хянах боломжтой болгох
- Гар утасны аппликэйшн (эмийн болон эмчид үзүүлэх санулагатай, гэр бүлийн гишүүд нь давхар хянах боломжтой)

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих

- Өвчтөний клуб ажиллуулж-АГ-тэй үйлчлүүлэгчдийг чадваржуулах
- Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих сурталчилгааны ажилууд
- Сайн санааны туслагч нарын оролцоог нэмэгдүүлэх

Эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх

- Нотолгоонд суурилсан, мэдээллээр хангах

Эрүүл ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх

- Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн “Шим тэжээл” бүлгийн хөтөлбөрийг боловсруулах
- Эрүүл ажлын байр бий болгох
- Хүнс үйлдвэрлэгчидтэй хамтарч ажиллах

СУРГАЛТЫН ЗОРИЛГО, СУРАЛЦАГЧИЙН ЭЗЭМШИХ УР ЧАДВАР

Артерийн гипертензийн тухай ерөнхий мэдээлэл болон Эрт илрүүлэлт:

- Артерийн гипертензийн тархалт түүний эрсдэлийн талаар мэдэх
- Артерийн гипертензийн хүндрэлийг ойлгох
- Үйлчлүүлэгчдэд системтэйгээр эрт илрүүлэг хийх ач холбогдлыг ойлгох
- Эрт илрүүлэг хийлгэхийн ач холбогдлыг үйлчлүүлэгчид ойлгуулах

Оношилгоо:

- Цусны даралтыг зөв хэмжиж сурна.
- Эмнэл зүйн удирдамжийн дагуу цусны даралтын түвшинг үнэлж сурна.
- Артерийн гипертензитэй бүх үйлчлүүлэгчдийн зүрх судасны өвчний эрсдлийг үнэлнэ.
- Артерийн гипертензитэй үйлчлүүлэгчийг төрөлжсөн мэргэжлийн эмчид илгээх заалтыг мэднэ.

Эмчилгээ:

- Артерийн гипертензитэй үйлчлүүлэгчид зааврын дагуу эмчилгээг эхлүүлэх (сувилагч: Артерийн гипертензийн эмчилгээ чухал болохыг ойлгосон)
- Зүрх судасны өвчний эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчид эмчилгээг даруй эхлүүлэх ба хянах чадвартай болно.
- Амьдралын хэв маяг өөрчлөх зүрх судасны эрсдэлт хүчин зүйлийг бууруулах



талаар зөвлөгөө өгч чадна.

- Даралт бууруулах хавсарсан эмийн эмчилгээнд хяналт тавьж чадна.
- Цусны даралт ихсэлттэй үйлчлүүлэгчийн хяналтыг сайжруулахад бүртгэлийн үйл ажиллагаа чухал болохыг ойлгосон, бүртгэлийн систем хэрэглэж сурна.

Үйлчлүүлэгчийг идэвхжүүлэх, хянах, эмийн тогтвортой хэрэглээ:

- Амьдралын хэв маягийг өөрчлөх ба эмийн эмчилгээний ач холбогдлыг ойлгож, үйлчлүүлэгчид эрүүл мэндийн боловсрол олгож чадна.
- Цусны даралт ихсэлттэй үйлчлүүлэгчийг идэвхжүүлэх ба эмийн тогтвортой хэрэглээг үнэлж чадна
- Цусны даралт ихсэлттэй үйлчлүүлэгч өөрөө өөрийгөө хянаж, эмээ тогтвортой хэрэглэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ

СУРАХУЙН АЯЛАЛ

Цахим орчинд суралцах:

1. Мэдээлэл
2. Сонжуур


Хичээлийн танхимд:

3. "Хийнгээ суралцах"
4. Тохиолдол дээр ажиллах
5. Дүрд толох
6. "Миний төлөвлөгөө"
7. Дахин сургалт

Үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

8. Цахим мэдээлэл, сургалт
9. Ажлын байран дээрх идэвхижүүлэлт
10. "Шавилан сургах" хөтөлбөр
11. Загвар СЭМТ

СЭМТ-ИЙН ДАРГА, ЭМЧ, СУВИЛАГЧ НАРЫН СУРАХУЙН АЯЛЛЫН ЗУРАГЛАЛ



СЭДЭВ 1. АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ТАРХВАР ЗҮЙ, ОНОШИЛГОО

СУРГАЛТЫН ЗОРИЛГО

Зорилго: танай СЭМТ-өөр үйлчлүүлж буй иргэдийн АГ-ийн Оношилгоог сайжруулахад оршино.

Өнөөдрийн сургалтаар дараах зүйлийг сурсан байна:

1. АГ, түүний эрсдэлт хүчин зүйлийн талаар ойлгосон
2. АГ-ийн тархалт, уг өвчний хор уршгийн талаар ойлгосон
3. Цусны даралтыг зөв хэмждэг болсон
4. Алгоритмын дагуу АГ-ийг зөв оношилж сурсан
5. Цусны даралт ихтэй бүх үйлчлүүлэгчдэд хүснэгтийг ашиглан ЗСӨ-ний эрсдэлийг үнэлж сурсан
6. АГ-тэй үйлчлүүлэгчийг нарийн мэргэжлийн эмчид илгээх заалтыг ойлгосон

ЦУСНЫ ДАРАЛТЫГ ЗӨВ ХЭМЖИХ АЧ ХОЛБОГДОЛ

Цусны даралтанд нөлөөлөх хүчин зүйл	
Орчин	Даарах үед ЦД нэмэгддэг
Архи, тамхи, кафейны хэрэглээ	ЦД нэмэгдүүлдэг тул хэрэглэсэн тохиолдолд багадаа 30 мин дараа ЦД хэмжүүлэх
Ачаалал	Хэмжихийн өмнө 3-5 мин тайван суухгүй бол ЦД-ыг 10 -20 мм МУБ-аар өөрчилдөг
Сэтгэл зүйн байдал	Сэтгэл хөдөлсөн, тайван бус байдал даралтын түвшинд нөлөөлдөг
Гар, нуруу, хөлний ул хөндий байх	Нуруу сандлын түшлэгээс хөндий байх нь 6 мм МУБ, хөл бүтэн улаараа тавиагүй байвал 2-8 мм МУБ, гар зүрхний түвшнээс дээгүүр эсвэл доогуур байх нь 3- 5 мм МУБ-аар тус тус өөрчилдөг
Зузаан хувцастай, давсаг дүүрэн байх	Зузаан хувцастай байх нь ЦД-ыг 10-50, давсаг дүүрэн байх нь 15 ммМУБ-аар тус тус нэмэгдүүлдэг
Манжетны урт	Хэт богино, жижиг байх нь даралтыг 10-40 мм МУБ-аар нэмэгдүүлдэг



ДАРАЛТ ЗӨВ ХЭМЖИХ ЗӨВЛӨГӨӨ

ДАВСГАА СУЛЛАСАН БАЙХ

Давсаг дүүрэн үед 10-15 нэгж илүү заадаг

5 МИН ХҮЛЭЭХ

Даралтаа хэмжүүлэхээс өмнө
5 минут тайван сууж, амрах
хэрэгтэй

ХӨЛИЙН УЛЫГ ШАЛАНД БҮРЭН ТУЛГАХ

Өлмий дээр тулсан үед 5-10
нэгж илүү заадаг

ХӨЛӨӨ АЧИХГҮЙ СУУХ

Хөлөө ачсан үед 2-8 нэгж
илүү заадаг

САНДЛЫН ТҮШЛЭГ НАЛЖ СУУХ

Түшлэгээ бүрэн налж суугаагүй
үед 5-10 нэгж илүү заадаг

ХАНЦУЙГАА ШУУХ

Хувцасны гадна талаас хэмжсэн
үед 10-40 нэгж илүү заадаг

ЗҮРХТЭЙ ХАРАЛДАА БАЙРЛУУЛАХ

Буруу байрлуулсан үед 10-13
нэгж илүү заадаг

ЯРЬЖ БОЛОХГҮЙ

Даралт хэмжиж байх үед ярих нь
10-15 нэгж илүү заадаг



ЦД ХЭМЖИХ ТЕХНИК-ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ЗӨВ ХИЙЖ БУЙ ҮЙЛДЛИЙГ ЗӨВЛӨНӨ ҮҮ)

Техник	Зөв	Сайжруулах шаардлагатай
1. Үйлчлүүлэгчийг тайван 5 мин суухыг зөвлөж байна	✓	
2. Давсгаа сулласан эсэхийг асууж байна		✓
3. Архи ууж, тамхи татсан эсэхийг асууж байна		
4. Кафеин агуулсан зүйл хэрэглэсэн эсэхийг асууж байна		
5. Даралт бууруулах эм уусан эсэхийг асууж байна		
6. Хэмжилт хийж байхад ярихгүй байхыг зөвлөж байна		
7. Хэмжилт хийхдээ зузаан хувцастай бол тайлуулж байна		
8. Хөлийг улаар нь бүтэн тавиулж байна		
9. Гарыг зүрхний түвшинд байрлуулж байна		
10. Манжетыг зөв байрлуулж байна		
11. Хэмжилтийг 2 гарт хийж байна		
12. Хэмжилтийг 2-3 удаа хийж, үзүүлэлтийн дунджаар даралтын түвшинг тодорхойлж байна		
13. Бусад ажиглалтууд (тухайлбал, гормоны бэлдмэл уусан эсэх гэх мэт даралт нэмэгдэхэд нөлөөлж болох эрсдэлийн талаар тодруулах)		

АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ОНОШИЛГООНЫ АЛГОРИТМ

Эрсдэл гэж юу вэ?

1. Тодорхой хугацааны туршид (хүн амын тодорхой бүлэгт) тохиолдож болох өвчний магадлал юм.
2. Зүрх судасны өвчин (ЗСӨ)-ий эрсдэл гэдэг нь тодорхой хугацаанд (ихэвчлэн 10 жилийн хугацаанд) ЗСӨ-өөр өвдөх магадлалыг хэлж байгаа юм.

ЗСӨ-НИЙ ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС



ТАМХИ ТАТАХ



АРХИ УУХ



АРТЕРИЙН ДАРАЛТ
ИХСЭХ



ЦУСНЫ ХОЛЕСТЕРИН
ИХ БАЙХ



ТАРГАЛАЛТ



ХӨДӨЛГӨӨНИЙ
ДУТАГДАЛ



ЭРҮҮЛ БУС ХООЛЛОЛТ



ЧИХРИЙН ШИЖИН



ЗСӨ-НИЙ ЭРСДЭЛИЙН ХҮСНЭГТ ДЭЭР АЖИЛЛАЯ

Жишээ:

- 75 настай, тамхи татдаг, эрэгтэй, СД 150 мм МУБ, холестерин түвшин 7,5 ммоль/л
- 36 настай, эмэгтэй, тамхи татдаг, СД 150 мм МУБ, холестерин түвшин 4,6 ммоль/л
- 57 настай, эрэгтэй, тамхи татдаггүй, СД 170 мм МУБ, холестерин түвшин 8,3 ммоль/л
- 68 настай, эмэгтэй, тамхи татдаг, СД 160 мм МУБ өөрсдийн эрсдэлийг тооцно уу!

Тайлбар:

ЗСӨ-ний нийт эрсдэл гэдэг нь ирэх 10 жилд аминд халтай, халгүй ЗСӨ-нөөр өвдөх магадлал юм.

ЗСӨ-д өртөх эрсдэл өндөр гэдэг нь ирэх 10 жилд аминд халтай, халгүй ЗСӨ-нөөр өвдөх магадлал $\geq 20\%$. Үүнд:

- Өмнө нь ЗСӨ оношлогдсон
 - Чихрийн шижинтэй
 - Холестерины түвшин эрс ихэссэн гэх мэт эрсдэлтэй
- Эсвэл:**
- Бай эрхтэний гэмтэлтэй

Өндөр эрсдэл гэдэгт эрсдлийн түвшин $\geq 20\%$ тооцох

Эрсдлийн түвшин										Холестерины түвшин (ммоль/л)									
<10% 10-<20% 20-<30% 30-<40% ≥40%																			
Нас (жил)	Эрэгтэй								Эмэгтэй								СД (мм МУБ)		
	Тамхи татдаггүй				Тамхи татдаг				Тамхи татдаггүй				Тамхи татдаг						
70																		180	
																		160	
																		140	
																		120	
60																		180	
																		160	
																		140	
																		120	
50																		180	
																		160	
																		140	
																		120	
40																		180	
																		160	
																		140	
																		120	
	4	5	6	7	8							4	5	6	7	8			
Холестерины түвшин (ммоль/л)																			

Зураг 1а. ЗСӨ-ний эрсдлийн түвшинг тодорхойлох
(цусны холестерин хэмжээг үзэж болох газарт хэрэглэх)

Нас (жил)	Эрэгтэй		Эмэгтэй		СД (мм МУБ)
	Тамхи татдаггүй	Тамхи татдаг	Тамхи татдаггүй	Тамхи татдаг	
70					180
					160
					140
					120
60					180
					160
					140
					120
50					180
					160
					140
					120
40					180
					160
					140
					120

Зураг 1б. ЗСӨ-ний эрсдлийн түвшинг тодорхойлох
(цусны холестерин хэмжээг үзэх боломжгүй газарт хэрэглэх)

Үүнд:

- ## АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ОНОШИЛГООНЫ АЛГОРИТМ



** ЗСӨ-ний дунд зэргийн эрсдэл: Ойрын 10 жилд ЗСӨ-өөр өвдөх магадлал 10-20%.

ДАСГАЛ

Жишээ 1:

- Үйлчлүүлэгч А-гийн систолын даралт 190 мм МУБ байна
- Таны дүгнэлт?



Жишээ 2:

- Үйлчлүүлэгч Б., 38 настай, эрэгтэй, анх удаа танай төвд ирэхэд СД 140 мм МУБ, тамхи татдаггүй, цусан дахь холестерин 8,0 ммол/л
- Таны дүгнэлт?



Жишээ 3:

- Үйлчлүүлэгч танай төвд 2 дах удаагаа ирэхэд систолын даралт 165 мм МУБ, чихрийн шижин шинээр оношлогдоод байгаа
- Таны дүгнэлт?



ӨВӨРМӨЦ НӨХЦЛИЙН АГ-ИЙН ТАЛААР ЯРИЛЦЬЯ!

- | | |
|---|--|
| ✓ Хүндрэлгүй анхдагч гипертензи | ✓ Тосгуурын мерцани |
| ✓ Өндөр настан | ✓ Бодисын солилцооны хам шинж |
| ✓ Чихрийн шижин | ✓ Эмэгтэйчүүдийн гипертензи |
| ✓ Бөөрний өвчин | ✓ Жирэмсэн үеийн АГ |
| ✓ Тархи-судасны эмгэг | ✓ Хоёрдогч гипертензи |
| ✓ Ухамсарт ухааны доройтол болон зөнөгрөл | ✓ Тэсвэрлэг гипертензи |
| ✓ Зүрхний титэм судасны өвчин ба зүрхний дутагдал | ✓ Яаралтай тусламж шаардлагатай гипертензи |
| ✓ Зүрхний дутагдал | ✓ Хоруу явцтай гипертензи |
- (Тодруулсан нь элбэг тохиолддог)

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМЧИД ИЛГЭЭХ ЗААЛТ

- Гипертензийн хямрал (криз)
- Хоёрдогч АГ
- Өвөрмөц нөхцлийн АГ

Бай эрхтэний гэмтэл илрүүлэх:

- Зүрх
- Бөөр
- Нүдний уг харах
- Цусны судасны эмгэгийг илрүүлэх

ЭМНЭЛ ЗҮЙН ТОХИОЛДЛУУД

- Өвчтөн В, 44 настай, эрэгтэй. Ердийн урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэхээр ирсэн.
- В нь дунд шатны менежер, суугаа ажилтай. Одоогоор зовуургүй. Түүний эцэг 15 жилийн өмнө “ЧШ-ийн хэв шинж 2” гэж оношлогдсон.
- В нь тамхи татдаг. (өдөрт 1 хайрцаг) Архи хэтрүүлэн хэрэглэдэггүй.

Жин 88 кг, Өндөр 178 см, АД 160/95ммМУБ (давтан хэмжилтээр) Нийт холестерин– 7,4ммоль/л, Өлөн үеийн цусны глюкоз – 6,6 ммоль/л

Өвчтөн -Х

Өвчтөн Х, 51 настай, эмэгтэй

Тэрээр үе үе нүүр халуу оргино гэсэн зовиуртай. Энэ шинж сарын тэмдэг алдагдах үед илрээд байна уу гэж таамаглаж байгаа. Х нь жижиг компанийн нягтлан бодогч, гэрлэсэн, 2 хүүхэдтэй.

- Тамхи татдаггүй
- Согтууруулах ундаа хааяа хэрэглэдэг
- Жин: 90кг
- Өндөр: 170 см
- АД: 150/90 ммМУБ (2 дах ирэлтээр)
- Нийт холестерин: – 6,0 ммоль/л
- Өлөн үеийн цусны глюкоз: – 5,5 ммоль/л

Өвчтөн -Ү

Өвчтөн Ү, 35 настай, эрэгтэй

Шинэ ажилд орох эрүүл мэндийн хуудас бөглүүлэхээр ирсэн. Тэр урьд нь биеийн хүчний ажил хийдэг байсан (барилгачин). Ү одоогоор зовиургүй. Эцэг нь 49 настайдаа “зүрхний бах” гэж оношлогдож байсан.

- Тамхи татдаг (өдөрт 1,5 хайрцаг)
- Архи тогтмол хэрэглэдэг (өдөрт дунджаар 200 мл-ийг уудаг)
- Жин: 78кг
- Өндөр: 178 см
- АД: 140/85 ммМУБ (анхны ирэлтээр)
- Өлөн үеийн цусны глюкоз: – 6,0 ммоль/л

Өвчтөн -З

Өвчтөн З, 68 настай, эмэгтэй

Толгой эргэнэ, гуйвна, нүд бүрэлзэнэ гэсэн зовиуртай. З нь тэтгэвэрт гарсан, хувиараа мал аж ахуй эрхэлдэг байсан. Гэрлэсэн, 4 хүүхэдтэй.

- Тамхи татдаггүй
- Согтууруулах ундаа хааяа хэрэглэдэг
- Жин: 92кг
- Өндөр: 174 см
- АД: 180/110 ммМУБ
- Нийт холестерин: – 7,8 ммоль/л
- Өлөн үеийн цусны глюкоз: – 8,2 ммоль/л



ӨНӨӨДӨР МИНИЙ МЭДСЭН ЗҮЙЛ

Доорх хүснэгтийг бөглөнө үү.

Ерөнхий мэдээлэл, тархвар зүй

1. Юуг мэдэж авсан

2. Юуг тодруулах

Цусны даралтыг хэмжих

1. Юуг мэдэж авсан

2. Юуг тодруулах

Оношилгоо, ЗСӨ-ний эрсдэл

1. Юуг мэдэж авсан

2. Юуг тодруулах




АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ЭМНЭЛ ЗҮЙН ЗААВРЫН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Гурав болон түүнээс дээш удаагын хэмжилтээр СД 130мм МУБ буюу түүнээс дээш, ДД 80мм МУБ буюу түүнээс дээш хэмжээнд байхыг артерийн гипертензи гэнэ. Хэрэв даралт бууруулах эм ууж байгаа бол АД нь хэвийн хэмжээндээ байсан ч артерийн гипертензитай гэж оношлоно. Оношийг даралт бууруулах эмэн эмчилгээ эхлэхийн өмнөх АД-ын түвшинг үндэслэж тавина.

ЦАГААН ХАЛАДНЫ БА ДАЛД АГ-ИЙГ ИЛРҮҮЛЭХ (ЭМЭН ЭМЧИЛГЭЭГҮЙ ТОХИОЛДОЛ)



АД-ыг баталгаажсан төхөөрөмж ашиглан, олон улсад мөрддөг стандарт аргачлалын дагуу, нарийн нягт нямбай хэмжинэ. Артерийн гипертензийн оношийг систолын эсвэл диастолын даралт хоёулаа өндөр байхад тавина.

Насанд хүрэгчдийн даралтын түвшин, даралтын үе шат, зүрх судасны өвчний эрсдэл зэргийг хүснэгт 1, 2, 3, 4-ийг ашиглан тодорхойлно.

Оношийг бичихдээ

Артерийн гипертензи, даралтын түвшин хэддүгээр зэрэг болох, үе шат (бай эрхтэний гэмтэл), эрсдэл (ЗСӨ-ний эрсдэл, хүснэгтээр) гэсэн дарааллаар бичнэ.

Жишээ 1

Артерийн гипертензи, нэгдүгээр зэрэг, 1-р үе шат, бага эрсдэлтэй.

Харин хоёрдогч гипертензи байвал эхлээд АГ-ийн гарал үүсэл, зэрэг, үе шат, эрсдэл гэсэн дарааллаар бичнэ.

Жишээ 2

Бөөрний гипертензи, нэгдүгээр зэрэг, 2-р үе шат, дунд эрсдэлтэй.

Хоёрдогч артерийн гипертензи, хоёрдугаар зэрэг, чихрийн шижин хэв шинж 2.

Хүснэгт 1. Насанд хүрэгчдийн АД-ын түвшингийн ангилал

Ангилал	Систолийн даралт (СД мм МУБ)	Диастолын даралт (ДД мм МУБ)
Хэвийн	<120	<80
Ихэссэн	120-129	<80
Артерийн гипертензи		
1-р зэрэг	130-139	80-89
2-р зэрэг	>140	>90

Хүснэгт 2. Эмнэлгийн АД-ын түвшинтэй дүйцэх бусад түвшин (мм МУБ)

Эмнэлгийн	Гэрийн	Өдрийн	Шөнийн	Хоногийн
120/80	120/80	120/80	100/65	115/75
130/80	130/80	130/80	110/65	125/75
140/90	135/85	135/85	120/70	130/80
160/100	145/90	145/90	140/85	145/90

Хүснэгт 3. Бай эрхтэний гэмтлээс шалтгаалан эмнэл зүйн үе шатыг тогтоох

АГ 1 үе	бай эрхтэний гэмтэлгүй
АГ 2 үе	бай эрхтэний гэмтэлтэй (шинж тэмдэггүй)
АГ 3 үе	бай эрхтэний хүндрэлтэй (шинж тэмдэгтэй)

Үүнд:

- Эмийг бага тунгаас эхэлж, бүтэн тун хүртэл нэмэх
- Эмийн бүтэн тунд хүрсэний дараа өөр бүлгийн эмийг нэмэх
- Эмийн эмчилгээний тунг тохируулах явцад эмчийн үзлэгт ирэх хоорондын хугацаа 14 хоногоос 1 сар байна.

АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ

- Хэрэв АД 130/80 -139/89 мм МУБ байгаад ЗСӨ-ний эрсдэл өндөр бол 1 эмээр эмчилгээг эхлэх. АГ-ийн эмэн эмчилгээг ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч (ахфс), эсвэл ангиотензины рецепторыг хоригч (арх)-оор эхлэх
- Хэрэв Ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч (АХФС), эсвэл ангиотензины рецепторыг хоригч (АРХ) эмэнд харшилтай, таарахгүй АГ-ийн эмэн эмчилгээг кальцийн суваг хориглогчоор солих
- Зүрх дэлсэх, хавагнах шинж тэмдэгтэй бол үйлчлүүлэгч АГ-ийн эмэн эмчилгээг шээс хөөх эмээр эхлэх
- Хэрэв АД $\geq 140/90$ мм МУБ байвал хавсарсан эмийн эмчилгээг эхлэх буюу ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч (ахфс), эсвэл ангиотензины рецепторыг хоригч (арх) + шээс хөөх эмээр эхлэх

ЭМИЙН ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭНД АНХААРАХ

- Үзлэг бүрээр эмийн тогтвортой хэрэглээг үнэлэх
- АГ, түүний хүндрэл, эмчилгээний талаар үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагч нарыг сургах
- Эмийн эмчилгээний горим, амьдралын хэв маягийн зөвлөгөөг аль болох энгийн байлгах,
- Үйлчлүүлэгчийн эмийн хэрэглээг өдөр тутмын амьдралын хэв маягтай уялдуулах

ЭМЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛТОТ ТҮВШИН

- Систолын даралт 130 мм МУБ-аас бага, Диастолын даралт 80 мм МУБ-аас бага байх.

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ДАРААГИЙН ШАТЛАЛЫН ЭМЧИД ИЛГЭЭХ ЗААЛТ

- АГ-ийн хямрал буюу нэн яаралтай, хойшлуулшгүй эмчилгээт гипертензи гэж оношилсон тохиолдолд
- Өвчний түүх, эсвэл бодит үзлэгээр хоёрдогч АГ гэж үзсэн, өвчний хүндрэлтэй үед
- АД гэнэт цочмог ихсэх, эсвэл даамжрах үед
- АД бууруулах хавсарсан эмийн эмчилгээнд үр дүнгүй тохиолдолд
- Залуу насны хүмүүст АД ихэссэн тохиолдолд

МИНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ерөнхий мэдээлэл, тархалт

- Би артерийн гипертензийн тархвар зүйн талаар мэдээллийг бүрэн авсан
- Би артерийн гипертензи, түүний эрсдэл, хүндрэлийн талаар бүрэн мэдлэгтэй болсон

Цусны даралт хэмжилт

- Би цусны даралтыг зөв хэмжиж чадна

Оношлогоо

- Би алгоритмын дагуу артерийн гипертензийг зөв оношилж чадна
- Би хүснэгтийг ашиглан ЗСӨ-ний эрсдэлийг үнэлж сурсан
- Би артерийн гипертензитай үйлчлүүлэгчийг нарийн мэргэжлийн эмчид илгээх заалтыг ойлгосон

Цаашдын зорилт?

Өнөөдрийн сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд ямар хүндрэл тулгарч болох

Хүндрэлийг шийдэх арга зам

ҮНЭЛГЭЭ

Би юу ч мэдэхгүй
Би сайн мэднэ,
бусдад зааж чадна



1	2	3	4	5
1	2	3	4	5
1	2	3	4	5

СЭДЭВ 2. АРТЕРИЙН ГИПЕРТЕНЗИЙН ЭМЧИЛГЭЭ, ХЯНАЛТ

Танай ӨЭМТ-д хяналтанд байдаг, эмчилгээ хийлгэдэг АГ-тэй үйлчлүүлэгчдийн өвчний менежмент, хяналтыг сайжруулахад оршино. Зорилгодоо хүрэхэд дараах 4 чиглэлээр мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнд:

АГ-ийн эмчилгээ, хяналт, эмийн тогтвортой хэрэглээг сайжруулахад дараах зүйл сурсан байна:

1. Эмчилгээний алгоритмыг ашиглан эмчилгээг зөв эхлүүлж сурсан (сувилагч нар: АГ-ийн эмчилгээний ач холбогдлыг бүрэн ойлгосон)
2. Амьдралын хэв маяг өөрчлөх буюу эмийн бус эмчилгээг эмийн эмчилгээтэй хослуулан хийж, ЦД-ыг зорилтот түвшинд хянаж сурсан
3. Амьдралын хэв маяг өөрчлөх болон ЗСӨ-ний эрсдэлийн талаар зөвлөгөө өгч сурсан
4. Даралт бууруулах эмийг тогтвортой хэрэглэх талаар зөвлөгөө өгч, тогтвортой хэрэглэж байгаа эсэхийг үнэлж сурсан

ЦУСНЫ ДАРАЛТЫГ ЗӨВ ОНОШИЛЖ, ЗОХИСТОЙ ЭМЧИЛГЭЭГ ХИЙХ АЧ ХОЛБОГДОЛ

Ямар ач холбогдолтой вэ?

1. Судас хатуурахаас сэргийлэх
2. Зүрхний шигдээсээс сэргийлэх
3. Тархины цус харвалтаас сэргийлэх
4. Захын судасны өвчнөөс сэргийлэх
5. Амьдралын чанарыг сайжруулах
6. Нийгэм эдийн засгийн дарамтыг багасгах?

ЭМЧИЛГЭЭНИЙ АЛГОРИТМ (ДЭМБ-ЫН ЗӨВЛӨМЖ)

АГ-ИЙН ЭМЭН ЭМЧИЛГЭЭГ АНГИОТЕНЗИН ХУВИРГАГЧ ФЕРМЕНТИЙГ СААТУУЛАГЧ (АХФС):
ЭСВЭЛ АНГИОТЕНЗИНЫ РЕЦЕПТОРЫГ ХОРИГЧ (АРХ)-ООР ЭМЧЛЭХ ПРОТОКОЛ

Шат 1

Насанд хүрсэн бүх хүнд АГ-ийн илрүүлэг хийх

Шат 2

Хэрвээ СД $\geq$ 130мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол АХФС,
эсвэл АРХ эхлэх тунгаар бичих

1 сарын дараа Шат 3

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол
АХФС эсвэл АРХ тунг нэмэх

1 сарын дараа Шат 4

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол
кальцийн суваг хориглогчийн тунг нэмэх

1 сарын дараа Шат 5

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол
кальцийн суваг хориглогчийн тунг нэмэх

1 сарын дараа Шат 6

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол тиазид
тест шээс хөөх эмийг нэмэх

1 сарын дараа Шат 7

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол өвчтөн
эмээ тогтмол, зөв хэрэглэж байгаа эсэхийг шалгах. Үр
дүнгүй бол нарийн мэргэжлийн эмчид хандах

Эмийн бэлдмэл ба тун

Бүлэг	Эмийн нэр	Эхлэх тун	Нэмэгдсэн тун
АХФС- (ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч)	Лизиноприл	20 Мг	40 Мг
	Рамиприл	5 мг	10 мг
	Периндоприл	4-5 мг	8-10 мг
АРХ- (ангиотензины рецепторыг хориглогч)	Лозартан	50 мг	100 мг
	Телмисартан	40 мг	80 мг
Шээс хөөх (тиазид тест)	Хлортиазид	12.5 мг	25 мг
	Хлорталидон	12.5 МГ	25 мг
	Индапамид	1.5 Мг	1.5 мг
Кальцийн суваг хориглогч	Амлодипин	5 мг	10 мг

Энэхүү протокол нь жирэмсэн болон жирэмсэн байж болзошгүй эмэгтэйчүүдэд эсрэг заалттай болно.

- ЧШ-тэй бол чихрийн шижин өвчний заавар, стандарт, удирдамжийн дагуу хянана.

БҮХ ӨВЧТӨНД АМЬДРАЛЫН
ХЭВ МАЯГ ӨӨРЧЛӨХ ЗӨВЛӨГӨӨ
ӨГӨХ (тодруулах)

- Тамхинаас татгалзах, дам тамхидалтаас зайлсхийх
- Архи уухгүй байх, зайлашгүй тохиолдолд өдөрт эрэгтэйчүүд 2 стандарт*, эмэгтэйчүүд 1 стандартаас бага хэрэглэх, архидалтаас зайлсхийх. *Нэг стандарт уулт: жижиг лаазтай шар айраг (330 мл), нэг хундага улаан дарс (100мл), 50мл архи (эдгээрийн аль нэгийг хэрэглэх).*
- 7 хоногт 150 минут идэвхитэй хөдөлгөөн хийх
- Илүүдэл жинтэй үед жингээ бууруулах
- Зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулах эрүүл хоол хүнс хэрэглэх
- Давс багатай хоол идэх
- Өдөрт 5 ба түүнээс дээш нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэх
- Эрүүл тос хэрэглэх (оливын тос зэрэг)
- Самар, бүхэл үр тариа, кали ихтэй хоол хүнс хэрэглэх
- Өөх тос ихтэй махны хэрэглээг багасгах
- Загасны мах болон омега-3 өөхний хүчлээр баялаг хоол хүнсийг 7 хоногт 2 ба түүнээс дээш удаа хэрэглэх
- Сахар ихээр агуулсан бялуу, жигнэмэг, чихэр, хийжүүлсэн ундаа, жүүс зэргийг хэрэглэхээс зайлсхийх

АГ-ИЙН ЭМЭН ЭМЧИЛГЭЭГ ШЭЭС ХӨӨХ ЭМЭЭР ЭХЛЭХ ПРОТОКОЛ

Шат 1

Насанд хүрсэн бүх хүнд АГ-ийн илрүүлэг хийх

Шат 2

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол тиазид төст шээс хөөх эмийг бичих

1 сарын дараа Шат 3

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол АХФС, эсвэл АРХ эхлэх тунгаар нэмэх

1 сарын дараа Шат 4

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол АХФС, эсвэл АРХ тунг нэмэх

1 сарын дараа Шат 5

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол кальцийн суваг хоригчлогчийг эхлэх тунгаар нэмэх

1 сарын дараа Шат 6

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол кальцийн суваг хоригчлогчийн тунг нэмэх

1 сарын дараа Шат 7

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол өвчтөн эмээ тогтмол, зөв хэрэглэж байгаа эсэхийг шалгах. Үр дүнгүй бол нарийн мэргэжлийн эмчид хандах

Эмийн бэлдмэл ба тун

Бүлэг	Эмийн нэр	Эхлэхтун	Нэмэгдсэн тун
Шээс хөөх (тиазид төст)	Хлортиазид	12.5 мг	25 мг
	Хлорталидон	12.5 мг	25 мг
	Индапамид	1.5 мг	1.5 мг
АХФС- (ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч)	Лизиноприл	20 мг	40 мг
	Рамиприл	5 мг	10 мг
	Периндоприл	4-5 мг	8-10 мг
АРХ (ангиотензины рецепторыг хориглогч)	Лозартан	50 мг	100 мг
	Телмисартан	40 мг	80 мг
Кальцийн суваг хориглогч	Амлодипин	5 мг	10 мг

Энэхүү протокол нь жирэмсэн болон жирэмсэн байж болзошгүй эмэгтэйчүүдэд эсрэг заалттай болно.

- ЧШ-тэй бол чихрийн шижин өвчний заавар, стандарт, удирдамжийн дагуу хянана.

БҮХ ӨВЧТӨНД АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ ӨӨРЧЛӨХ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ (тодруулах)

- Тамхинаас татгалзах, дам тамхидалтаас зайлсхийх
- Архи уухгүй байх, зайлашгүй тохиолдолд өдөрт эрэгтэйчүүд 2 стандарт*, эмэгтэйчүүд 1 стандартаас бага архи уух, архидалтаас зайлсхийх. *Нэг стандарт уулт: жижиг лаазтай шар айраг (330 мл), нэг хундага улаан дарс (100мл), 50мл архи (эдгээрийн аль нэгийг хэрэглэх).*
- 7 хоногт 150 минут идэвхитэй хөдөлгөөн хийх
- Илүүдэл жинтэй үед жингээ бууруулах
- Зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулах эрүүл хоол хүнс хэрэглэх
- Давс багатай хоол идэх
- Өдөрт 5 ба түүнээс дээш нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэх
- Эрүүл тос хэрэглэх (оливын тос зэрэг)
- Самар, бүхэл үр тариа, кали ихтэй хоол хүнс хэрэглэх
- Өөх тос ихтэй махны хэрэглээг багасгах
- Загасны мах болон омега-3 өөхний хүчлээр баялаг хоол хүнсийг 7 хоногт 2 ба түүнээс дээш удаа хэрэглэх
- Сахар ихээр агуулсан бялуу, жигнэмэг, чихэр, хийжүүлсэн ундаа, жүүс зэргийг хэрэглэхээс зайлсхийх

АНГИОТЕНЗИН ХУВИРГАГЧ ФЕРМЕНТИЙГ СААТУУЛАГЧ (АХФС), ЭСВЭЛ АНГИОТЕНЗИНЫ РЕЦЕПТОР ХОРИГЧ (АРХ) + ШЭЭС ХӨӨХ ЭМЭЭР ЭМЧЛЭХ ПРОТОКОЛ

Шат 1

Насанд хүрсэн бүх хүнд АГ-ийн илрүүлэг хийх

Шат 2

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол АХФС эсвэл АРХ-ийг тиазид төст шээс хөөх эмтэй хавсрах

1 сарын дараа Шат 3

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол АХФС эм эсвэл АРХ, тиазид төст шээс хөөх эмийн тунг нэмэх

1 сарын дараа Шат 4

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол кальцийн суваг хориглогчийг эхлэх тунгаар нэмэх

1 сарын дараа Шат 5

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол кальцийн суваг хориглогчийг тунг нэмэх

1 сарын дараа Шат 6

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол тиазид төст шээс хөөх эмийн тунг нэмэх

1 сарын дараа Шат 7

Хэрвээ АД $\geq$ 140, эсвэл $\geq$ 90 бол өвчтөн эмээ тогтмол, зөв хэрэглэж байгаа эсэхийг шалгах. Үр дүнгүй бол нарийн мэргэжлийн эмчид хандах

Эмийн бэлдмэл ба тун

Бүлэг	Эмийн нэр	Эхлэхтун	Нэмэгдсэн тун
АХФС- (ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч)	Лизиноприл	20 мг	40 мг
	Рамиприл	5 мг	10 мг
	Периндоприл	4-5 мг	8-10 мг
АРХ (ангиотензины рецепторыг хориглогч)	Лозартан	50 мг	100 мг
	Телмисартан	40 мг	80 мг
Шээс хөөх (тиазид төст)	Хлортиазид	12.5 мг	25 мг
	Хлорталидон	12.5 мг	25 мг
	Индапамид	1.5 мг	1.5 мг
Кальцийн суваг хориглогч	Амлодипин	5 мг	10 мг

Энэхүү протокол нь жирэмсэн болон жирэмсэн байж болзошгүй эмэгтэйчүүдэд эсрэг заалттай болно.

- ЧШ-тэй бол чихрийн шижин өвчний заавар, стандарт, удирдамжийн дагуу хянана.

БҮХ ӨВЧТӨНД АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ ӨӨРЧЛӨХ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ

- Тамхинаас татгалзах, дам тамхидалтаас зайлсхийх
- Архи уухгүй байх, зайлашгүй тохиолдолд өдөрт эрэгтэйчүүд 2 стандарт*, эмэгтэйчүүд 1 стандартаас бага архи уух, архидалтаас зайлсхийх. *Нэг стандарт уулт: жижиг лаазтай шар айраг (330 мл), нэг хундага улаан дарс (100мл), 50мл архи (эдгээрийн аль нэгийг хэрэглэх).*
- 7 хоногт 150 минут идэвхитэй хөдөлгөөн хийх
- Илүүдэл жинтэй үед жингээ бууруулах
- Зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулах эрүүл хоол хүнс хэрэглэх
- Давс багатай хоол идэх
- Өдөрт 5 ба түүнээс дээш нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэх
- Эрүүл тос хэрэглэх (оливын тос зэрэг)
- Самар, бүхэл үр тариа, кали ихтэй хоол хүнс хэрэглэх
- Өөх тос ихтэй махны хэрэглээг багасгах
- Загасны мах болон омега-3 өөхний хүчлээр баялаг хоол хүнсийг 7 хоногт 2 ба түүнээс дээш удаа хэрэглэх
- Сахар ихээр агуулсан бялуу, жигнэмэг, чихэр, хийжүүлсэн ундаа, жүүс зэргийг хэрэглэхээс зайлсхийх



АГ-ИЙН ЭМЭН ЭМЧИЛГЭЭГ КАЛЬЦИЙН СУВАГ ХОРИГЛОГЧООР ЭМЧЛЭХ ПРОТОКОЛ

Шат 1

Насанд хүрсэн бүх хүнд АГ-илрүүлэг хийх

Шат 2

Хэрвээ СД $\geq$ 130мм МУБ ба ДД $\geq$ 80мм МУБ бол кальцийн суваг хориглогчийг эхлэх тунгаар бичих

1 сарын дараа Шат 3

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80мм МУБ бол кальцийн суваг хориглогчийн тунг нэмэх

1 сарын дараа Шат 4

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80мм МУБ бол АХФС эсвэл АРХ-ийг эхлэх тунгаар нэмэх

1 сарын дараа Шат 5

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80мм МУБ бол АХФС эсвэл АРХ тунг нэмэх

1 сарын дараа Шат 6

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол тиазид төст шээс хөөх эмийг нэмэх

1 сарын дараа Шат 7

Хэрвээ СД $\geq$ 130 мм МУБ ба ДД $\geq$ 80 мм МУБ бол өвчтөн эмээ тогтмол, зөв хэрэглэж байгаа эсэхийг шалгах. Үр дүнгүй бол нарийн мэргэжлийн эмчид хандах

Эмийн бэлдмэл ба тун

Бүлэг	Эмийн нэр	Эхлэх тун	Нэмэгдсэн тун
Кальцийн суваг хориглогч	Амлодипин	5 мг	10 мг
АХФС- (ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч)	Лизиноприп	20 Мг	40 Мг
	Рамиприл	5 мг	10 мг
	Периндоприл	4-5 мг	8-10 мг
АРХ- (ангиотензины рецепторыг хориглогч)	Лозартан	50 мг	100 мг
	Телмисартан	40 мг	80 мг
Шээс хөөх (тиазид тест)	Хлортиазид	12.5 мг	25 мг
	Хлорталидон	12.5 мг	25 мг
	Индапамид	1.5 мг	1.5 мг

- ЧШ-тэй бол чихрийн шижин өвчний заавар, стандарт, удирдамжийн дагуу хянана.

БҮХ ӨВЧТӨНД АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ ӨӨРЧЛӨХ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ

- Тамхинаас татгалзах, дам тамхидалтаас зайлсхийх
- Архи уухгүй байх, зайлашгүй тохиолдолд өдөрт эрэгтэйчүүд 2 стандарт*, эмэгтэйчүүд 1 стандартаас бага архи уух, архидалтаас зайлсхийх. *Нэг стандарт уулт: жижиг лаазтай шар айраг (330 мл), нэг хундага улаан дарс (100мл), 50мл архи (эдгээрийн аль нэгийг хэрэглэх).*
- 7 хоногт 150 минут идэвхитэй хөдөлгөөн хийх
- Илүүдэл жинтэй үед жингээ бууруулах
- Зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулах эрүүл хоол хүнс хэрэглэх
- Давс багатай хоол идэх
- Өдөрт 5 ба түүнээс дээш нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэх
- Эрүүл тос хэрэглэх (оливын тос зэрэг)
- Самар, бүхэл үр тариа, кали ихтэй хоол хүнс хэрэглэх
- Өөх тос ихтэй махны хэрэглээг багасгах
- Загасны мах болон омега-3 өөхний хүчлээр баялаг хоол хүнсийг 7 хоногт 2 ба түүнээс дээш удаа хэрэглэх
- Сахар ихээр агуулсан бялуу, жигнэмэг, чихэр, хийжүүлсэн ундаа, жүүс зэргийг хэрэглэхээс зайлсхийх

ДАСГАЛ

Жишээ 1:

- 58 настай, эрэгтэй, шинээр АГ оношлогдсон, АХФС-д харшилтай
- Таны эмчилгээ?



Жишээ 2:

- АГ-тэй эмэгтэй үйлчлүүлэгч, АХФС*+Тиазидын бүлгийн шээс хөөх эмийн хоногийн тунгийн ¼ ууж байгаа ч даралт зорилтот түвшиндээ хүртэл буугаагүй
- Таны эмчилгээ?



Жишээ 3:

- Жирэмсэн эмэгтэй, тиазидын бүлгийн шээс хөөх эмийн хоногийн тунг бүрэн авч байгаа ч даралт төдийлөн буурахгүй байгаа
- Таны эмчилгээ?

ӨВӨРМӨЦ НӨХЦЛИЙН АГ-ИЙН МЕНЕЖМЕНТ

- Гипертензийн хямрал (криз)
 - Өндөр настан (СД)
 - Чихрийн шижин
 - Бөөрний өвчин
 - Тосгуурын мерцани
 - Жирэмсний гипертензи
1. Нарийн мэргэжлийн эмчид илгээх заалттай
 2. Адилхан эм хэрэглэх боловч эмийн сонголт өөр байдгаараа ялгаатай
 3. ӨЭМТ дээр эмийн тогтвортой хэрэглээг хянах, үйлчлүүлэгчийг сэдэлжүүлэхэд анхаарах



ЭМЧИЛГЭЭНИЙ ТОХИОЛДОЛ ДЭЭР АЖИЛЛАХ ДАСГАЛ

Сэдэв. Эмчилгээ, эмийн тогтвортой хэрэглээ

Бүлэг 1:

- 64 настай эрэгтэй, АГ оношоор 15 жил эмчлэгдэж байна. Лизиноприл, гипотиазид ууж байгаад 2 сарын өмнөөс амлодипин хоногт 5 мг –аар ууж эхэлсэн. 1 сарын дараа ээлжит үзлэгтээ ирэхэд АД 160/100 мм МУБ байна.
- Таны эмчилгээ?

.....

.....

Бүлэг 2:

- 46 настай, эрэгтэй, тамхи татдаг, анхны ирэлтээр АД 150/90 мм МУБ, ЗЦ 88 удаа, ЧШХШ2-той
- Таны эмчилгээний шийдвэр?

.....

.....

Бүлэг 3:

